МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2003 оны 07 сарын 08 өдөр          Дугаар 235          Улаанбаатар хот

# Гадаадад суралцуулах тухай

"Өндөр хөгжилтэй орнуудад суралцагчдын асуудлаар санал, дүгнэлт гаргах комисс"-ын 2003 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн хурлын тэмдэглэл, Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайд, Санхүү, Эдийн засгийн сайдын 2001 оны 310/290 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан "Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын 2,6-г үндэслэн ТУШААХ НЬ:

1. Хайсамбуу овогтой Бат-Эрдэнийг АНУ-ын Вирджини Олон Улсын Их сургуулийн магистрантурт мэдээллийн системийн чиглэлээр, Бумцэнд овогтой Тэгшжаргалыг ХБНГУ-ын Нюрнберг хотын Фридрих Александрын Их сургуулийн магистрантурт, Далхжав овогтой Мөнхбатыг АНУ-ын Бриджпортын Их сургуулийн магистрантурт удирдлагын чиглэлээр, Жамцаа овогтой Цэвэлсүрэнг АНУ-ын Сан Францискогийн Улсын Их сургуулийн магистрантурт урлагийн сэтгэл судлалын чиглэлээр, Нанзаддорж овогтой Найданболдыг ХБНГУ-ын Билефельдийн Их сургуульд эдийн засгийн математикийн чиглэлээр, Эрдэнэсүрэн овогтой Амгаланг Австрали улсын La Trobe Их сургуулийн магистрантурт боловсролын удирдлагын чиглэлээр, Цэрэндоо овогтой Мөнхтөрийг АНУ-ын Боулдэр хот дахь Колорадогийн Их сургуулийн магистрантурт сэтгүүл зүйн чиглэлээр, Лхагвасүрэн овогтой Баярааг АНУ-ын Денвер хот дахь Колорадогийн Их сургуулийн магистрантурт бизнес, эдийн засгийн чиглэлээр, Төмөр овогтой Самбуунямыг АНУ-ын Де Врай Их сургуулийн магистрантурт бизнесийн удирдлагын чиглэлээр, Гомбожав овогтой Оюунгэрэлийг Австрали улсын Свинбурн Технологийн Их сургуулийн магистрантурт бизнесийн удирдлагын чиглэлээр, ~~Лхагвасүрэн овогтой Оюунбилэгийг АНУ-ын Джорж Майсоны Их сургуулийн магистрантурт хууль зүйн чиглэлээр~~ 2003-2004 оны хичээлийн жилээс 2 жилийн хугацаагаар тус тус суралцуулсугай.

БСШУ Сайдын 2003.10.27-ны өдрийн 360 дугаар тушаалаар хүчингүй болсон.

Сайдын 2003 оны 10 сарын 27 өдрийн 360 дугаар тушаалаар хүчингүй

2. Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайд, Санхүү, Эдийн засгийн сайдын 2001 оны 310/290 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан "Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын

дагуу суралцагчидтай гэрээ байгуулж, холбогдох төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /П.Лхагвасүрэн/, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Шинжлэх ухаан, технологи, дээд боловсролын бодлого, зохицуулалтын газар /М.Баасанжав/-т тус тус даалгасугай.

САЙД А.ЦАНЖИД